



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 500

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх,
ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 96,717,194.00 (ерэн зургаан сая долоон зуун арван долоон мянга нэг зуун ерэн дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, Үндэсний номын санд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001606

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны .11. дүгээр сарын /ний өдрийн
800 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨ
 БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа (жил)
1	Хуруу мэдрэгчтэй 55 инчийн ЛСД дэлгэц	2011.03.07	96,717,194.00	Үндэсний номын сан	2,000,000.00	2
			(ерэн зургаан сая долоон зуун арван долоон мянга нэг зуун ерэн дөрвөн)		(хоёр сая)	